


Баталгаажуулсан:

Холбооны удирдах зөвлөлийн дарга



 Ц.Дашзэвгэ

МГФЗЗХ-ны 2025 оны 09-р сарын 15-ны өдрийн ХУЗ-ийн хурлаар шинэчлэн батлав.



МОНГОЛЫН ГЕОДЕЗИ, ФОТОГРАММЕТР, ЗУРАГ ЗҮЙН МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНЫ ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Монгол улсын Геоматик /Гео орон зайн/ салбарын хувьд дэлхий дахины нийгэм, эдийн засгийн үсрэнгүй хөгжил, эрс шинэчлэлттэй уялдан зайлшгүй хөгжих шаардлага урган гарч байгаа билээ. Энэхүү хэрэгцээ, шаардлагын дагуу Монголын геодези, фотограмметр, зураг зүйн мэргэжлийн холбоо нь Монгол улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллагад хуулиар олгогдсон эрхийн дагуу хууль эрх зүйн баримт бичиг боловсруулах, геодези, зураг зүйн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, салбарын боловсон хүчний бодлогыг тодорхойлох зэрэгт дэмжлэг үзүүлэх, салбарт шинээр нэвтэрч байгаа техник технологийг нийтийн хүртээл болгох, нийтийг хамарсан сургалт зохион байгуулах, төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх замаар Монгол улсын хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах, гишүүдийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор байгуулагдсан улс төрийн аливаа нам эвслээс хараат бус, гишүүнчлэл бүхий нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага байна.
- 1.2. Монголын Геодези, Фотограмметр, Зураг Зүйн Мэргэжлийн Холбоо нь /цаашид Холбоо гэх/ анх “Монголын геодези, зураг зүйн холбоо” хэмээх оноосон нэрээр 2004 оны 5 сард Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлсэн бөгөөд 2009 оны 11 сарын 9-нд “Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо” нэрээр Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж баталгаажсан. Холбооны англи хэл дээрх албан ёсны нэр нь “Mongolian Association of Geodesy, Photogrammetry and Cartography” цаашид хураангуйгаар “MAGPC” гэж орчуулагдана.
- 1.3. Геоматик /Гео Орон Зайн/ салбар гэдэгт дараах чиглэлүүд багтсан байна.
 - Геодези
 - Геодинамик
 - Гидрографи
 - Навигаци
 - Зураг зүй
 - Фотограмметр
 - Газарзүй мэдээллийн систем
 - Тандан судлал
- 1.4. Холбооны төв нь Улаанбаатар хотод байрлах бөгөөд бусад аймаг, хотуудад өөрийн салбар нэгжтэй байж болно.
- 1.5. Холбоо нь Монгол улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ хэлэлцээр, тэдгээртэй нийцүүлэн

- МОНГОЛЫН ГЕОДЕЗИ, ФОТОГРАММЕТР, ЗУРАГ ЗҮЙН МЭРГЭЖЛИЙН
ХОЛБООНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



- 2.1. Холбооны үндсэн зорилго нь Монголын геодези, зураг зүйн салбарыг хөгжүүлэх, салбарын аж ахуйн нэгж болон инженер, техникийн ажилтан, гишүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах
- 2.2. Холбооны алсын хараа - Салбарын хамт олныг эгнээндээ бүрэн хамруулсан,

- олон улсын жишигт хүрсэн, манлайлал бүхий салбар болгох,
- 2.3. Холбоо нь үндсэн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:
- 2.3.1. Салбарын хууль, техникийн зохицуулалт, дүрэм, норм, журам, стандарт, заавар боловсруулахад оролцох, мэргэжлийн зөвлөгөө өгөх;
 - 2.3.2. Олон улсын ижил төстэй мэргэжлийн байгууллагатай харилцаа холбоо тогтоох, шинжлэх ухаан, технологийн мэдээлэл солилцох, хамтран ажиллах, хурал, зөвлөгөөн, сургалт, семинар зохион байгуулах;
 - 2.3.3. Мэргэжлийн боловсон хүчнийг давтан сургах, мэргэшүүлэх
 - 2.3.4. Мэргэжил, салбарын хүний нөөцийн чиглэлээр судалгаа хийж холбогдох байгууллагад уламжлах;
 - 2.3.5. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэж байгаа их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, мэргэжлийн индексд санал хүргүүлэх;
 - 2.3.6. Эрдэм шинжилгээний болон туршлага судалгааны ажлын эрэлт хэрэгцээг тодорхойлох;
 - 2.3.7. Салбарын үйл ажиллагаа, эрх зүйн баримт бичиг, тулгамдсан асуудлаар эрдэмтэн, мэргэжилтнүүд, олон нийт, гишүүдийг хамруулан хэлэлцүүлэг, сургалт, семинар, уулзалт, хэвлэлийн бага хурал, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах;
 - 2.3.8. Салбарын хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаа, гадаад, дотоодын туршлага, ололт амжилт, шинэ техник, технологийн талаарх мэдээллийг гишүүддээ хүргэх;
 - 2.3.9. Салбарын хөгжил, хэтийн төлөвтэй холбоотой асуудлыг бодлогын баримт бичигт тусгуулах, нийтийн эрэлтэд үндэслэн тодорхой санал, дүгнэлтийг холбогдох байгууллагад хүргэх;
 - 2.3.10. Гадаадын болон дотоодын байгууллагын хүсэлтээр мэргэжлийн зөвлөгөө өгөх;
 - 2.3.11. Салбарын хяналт хийхэд хамтран оролцох, эрх үүссэн тохиолдолд хяналт хийх;
 - 2.3.12. Салбарын сэтгүүл гаргах;
 - 2.3.13. Төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр хариуцан гүйцэтгэж, холбогдох зардлыг төрөөс гаргуулан авах;
 - 2.3.14. Мэргэжлээ дунд сургуулийн сурагчид, олон нийтэд сурталчилж байх.
 - 2.3.15. Олон улсын хэмжил, зураглаачдын өдрийг жил бүр тэмдэглэж байх
 - 2.3.16. Салбарын инженер, техникийн ажилтан, аж ахуйн нэгжүүдийг гишүүнээр элсүүлэх ажлыг эрэлхийлж холбооны цар хүрээг тэлж байх
 - 2.3.17. Олон нийтэд чиглэсэн тогтмол явуулдаг үйл ажиллагааг тасралтгүй явуулах
 - 2.3.18. Аливаа байгууллагаас гарсан шийдвэр нь гишүүдийн нийтлэг эрх ашгийг хөндсөн тохиолдолд уг асуудлыг залруулахын төлөө ажиллах
- 2.4. Холбоо нь гишүүн байгууллага, хувь хүнд дараах дэмжлэгийг үзүүлж ажиллана. Үүнд:
- 2.4.1. Мэргэжлийн чиглэлээр гадаад, дотоодын урт болон богино хугацааны сургалт, эрдэм шинжилгээний хурлын товыг мэдээлэх, оролцоход зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх;

- 2.4.2. Салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан, олон жил үр бүтээлтэй ажилласан гишүүнийг салбарын болон төрийн шагналд тодорхойлох, тэдгээрийн хөдөлмөрийг үнэлүүлэх ажлыг зохион байгуулах;
- 2.4.3. Гишүүдийн зүгээс хүсэлт гаргасан тохиолдолд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;
- 2.4.4. Мэргэжлийн чиглэлийн нээлттэй мэдээлэл, гарын авлага, норм, заавар, дүрмийг цахим системээр түгээх;
- 2.4.5. Гишүүдийн мэргэжлийн ур чадвар, ололт амжилтыг сурталчлах;
- 2.4.6. Холбооны нэрэмжит шагналаар гишүүн байгууллага, гишүүнийг шалгаруулж гэрчилгээ, өргөмжлөл олгож холбооны цахим хуудаст байрлуулан сурталчлах;
- 2.4.7. Цахим хуудсаараа дамжуулан гишүүн байгууллага, гишүүдийн мэдээллийг хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх түнш хайж байгаа, тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар геодези зураг зүйн бүх төрлийн ажил үйлчилгээ хийлгэхээр сонирхож буй гадаад, дотоодын төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүст холбооны гишүүдийн дэлгэрэнгүй мэдээллийн сангаас тохирох хамтрагчаа сонгох боломжоор хангах.

ГУРАВ. ХОЛБООНЫ ГИШҮҮНЧЛЭЛ

- 3.1. Холбооны зорилго, үйл ажиллагааг дэмжиж, дүрмийг хүлээн зөвшөөрсөн, аж ахуйн нэгж, иргэн гишүүнээр элсэнэ.
- 3.2. Холбооны цахим системд гишүүнчлэлээр бүртгэгдсэнээр гишүүний эрх үүснэ.
- 3.3. Холбооны гишүүн аж ахуйн нэг, иргэн нь гишүүнчлэлийн цахим гэрчилгээтэй байна.
- 3.4. Холбооны гишүүн аж ахуйн нэгж, иргэний эрх үүргийг журмаар зохицуулна.
- 3.5. Холбооны гишүүн нь дараах эрхтэй. Үүнд:
 - 3.5.1. Холбооны үйл ажиллагаанд тэгш эрхтэйгээр оролцох;
 - 3.5.2. Холбооны удирдлага бусад албан тушаалд өөрийн болон бусдын нэрийг дэвшүүлэх, сонгох, сонгогдох, томилогдон ажиллах, хуульд заасан үндэслэлээр болон өөрийн хүсэлтээр ажиллахаас татгалзах;
 - 3.5.3. Холбооны бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулахыг шаардах;
 - 3.5.4. Холбооны үйл ажиллагаатай танилцах, санал шүүмжлэл гаргах, үнэлэлт дүгнэлт өгөх.
- 3.6. Холбооны гишүүн нь дараах үүрэгтэй. Үүнд:
 - 3.6.1. Гишүүний татвараа цаг хугацаанд нь төлж байх;
 - 3.6.2. Холбооны дүрэм, журмыг дагаж мөрдөх, мэргэжлийн ёс зүйн зарчмыг баримталж ажиллах, холбооны нэр хүнд, хамтын эв нэгдлийг сахин хамгаалах;
 - 3.6.3. Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байх.
- 3.7. Гишүүний үйл ажиллагаанд дараах зүйлсийг хориглоно. Үүнд:
 - 3.7.1. Өөрт эрх олгогдоогүй асуудлаар Холбоог төлөөлөх, мэдэгдэл хийх, зорилгод нийцээгүй үйл ажиллагаа хэрэгжүүлэх;
 - 3.7.2. Гишүүн нь ижил зорилго, үйл ажиллагаатай төрийн бус байгууллага байгуулах;

- 3.8. Дараах тохиолдолд гишүүний эрх, үүрэг дуусгавар болно. Үүнд:
- 3.8.1. Хувь гишүүн нь нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон;
 - 3.8.2. Аж ахуйн нэгж нь татан буугдсан, үйл ажиллагаа явуулахаа больсон;
 - 3.8.3. Холбооноос явуулж байгаа үйл ажиллагаа нь тухайн гишүүний эрхийг зөрчсөн, эсвэл ашиг сонирхолд нь нийцэхгүй байгаа тохиолдолд гишүүн өөрийн хүсэлтээр өргөдөл гарган гишүүнчлэлээс татгалзсан;
 - 3.8.4. Холбооны дүрмийг санаатайгаар зөрчсөн, Холбооны болон салбарын нэр хүндийг унагасан, гишүүдийн нийтлэг эрх ашгийг зөрчсөн гэх мэт үйлдэл хийсэн нь тогтоогдсоны улмаас Холбооны удирдлагын шийдвэрээр гишүүнчлэлээс хассан;
- 3.9. Гишүүн татвараа төлөөгүйн улмаас гишүүнчлэлээс хасагдсан тохиолдолд журмын дагуу татвараа нөхөн төлөх замаар гишүүний эрхээ сэргээлгэнэ.
- 3.10. Холбооны гишүүн байгууллага, хувь хүн нь холбооны нэрийн өмнөөс аливаа ажил үйлчилгээ үзүүлж болох бөгөөд гагцхүү холбоотой гэрээ байгуулах ба холбоонд 15 хувийн хандив /шимтгэл/ өгсөн байна.

ДӨРӨВ. ХОЛБООНЫ БҮТЭЦ БҮРЭЛДЭХҮҮН, ТҮҮНИЙ ЭРХ ҮҮРЭГ

- 4.1. МГФЗЗМНХ нь өөрийн үйл ажиллагааг нээлттэй, бүх гишүүдэд хүртээмжтэй байлгахын тулд дараах бүтэцтэй байна. Үүнд:
- 4.1.1. Бүх гишүүдийн хурал
 - 4.1.2. Холбооны удирдах зөвлөл
 - 4.1.3. Тэргүүн
 - 4.1.4. Хяналтын зөвлөл
 - 4.1.5. Гүйцэтгэх захирал
 - 4.1.6. Ажлын алба
 - 4.1.7. Залуу инженерүүдийн клуб
- 4.2. Орон нутагт салбар зөвлөл байгуулж болно. Энэ тохиолдолд тухайн газарт байгаа ажиллагсдын төлөөллийг оролцуулсан албан ёсны хурлаар шийдвэрлэн тогтоол гаргаж МГФЗЗМНХ-нд бүртгүүлнэ.
- 4.3. Салбар зөвлөлүүд нь ХУЗ, ХЗ, Тэргүүний шийдвэр зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулж, МГФЗЗМНХ-ны нэгдмэл удирдлага зөвлөгөөг авч, ажлаа тайлагнана.

А. БҮХ ГИШҮҮДИЙН ХУРАЛ

- 4.5. Холбооны удирдах дээд байгууллага нь МГФЗЗМНХ-ны бүх гишүүдийн хурал байна.
- 4.6. Холбооны бүх гишүүдийн тайлангийн хурлыг жилд нэг удаа, сонгуульт хурал 3 жилд нэг удаа хуралдуулна. Ээлжит бус хурлыг гишүүдийн санал, санаачлагаар зарлан хуралдуулж болно.
- 4.7. Бүх гишүүдийн сонгуульт хурлыг 30 хоногийн өмнө нийтэд зарлан мэдээлнэ.
- 4.8. Бүх гишүүдийн хурлаар холбооны үйл ажиллагааны болон хяналтын зөвлөлийн тайланг хэлэлцэж, санал зөвлөмж гаргана.
- 4.9. Бүх гишүүдийн сонгуульт хурлаар холбооны удирдах зөвлөл /цаашид ХУЗ гэх/, хяналтын зөвлөлийн /цаашид ХЗ гэх/ гишүүдийг сонгож, чөлөөлнө.
- 4.10. Бүх гишүүдийн хурлыг чиглүүлэх, түүний явц, зохион байгуулалттай холбогдсон асуудлыг шийдвэрлэх, сонгууль удирдан явуулах, хурлын

- шийдвэрийг хэлбэржүүлэх, өмнөх ХУЗ, ХЗ-ийн гишүүдийг чөлөөлөх зэрэг үүрэг гүйцэтгэх хурал даргалагч болон нарийн бичгийн даргыг тухайн хурлаас сонгоно. Хурлын явцыг протоколд тэмдэглэж, түүнээс гарсан шийдвэрийг хурал даргалагч, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 4.11. ХУЗ, ХЗ-ийн сонгуулийг зохион байгуулах тооллогын комиссыг бүх гишүүдийн саналаар гурван хүний бүрэлдэхүүнтэй байгуулах ба тооллогын комисст орсон хүнийг ХУЗ-ийн гишүүнд нэрийг нь дэвшүүлэхгүй.
- 4.12. ХУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн хүсэлтийг 30 хоногийн өмнө урьдчилан бүртгэж, нэр дэвшигчийн танилцуулга, хөтөлбөрийг бүх гишүүдийн хурал хүртэл хугацаанд нийтэд цахимаар мэдээлнэ.
- 4.13. Бүх гишүүдийн сонгуульт хурлын явцад гишүүн өөрийн болон бусад гишүүний нэрийг танхимаас ХУЗ, ХЗ-ийн гишүүнд дэвшүүлж болно.
- 4.14. Нэр дэвшигчид сонгуульт хугацаанд хийж гүйцэтгэх ажлын хөтөлбөр танилцуулна.
- 4.15. ХУЗ нь 15-аас доошгүй сондгой тооны гишүүнтэй байх ба дараах зарчмаар гишүүдийг сонгоно. Үүнд:
- 4.15.1. ХУЗ-ийн гишүүдийг нууц санал хураалтаар сонгоно.
- 4.15.2. ХУЗ-д нэр дэвшигчийн тоог хязгаарлахгүй бөгөөд нууц санал хураалт явуулж, нэр дэвшигчдийг авсан саналын тоогоор жагсаан, эхний нэр дэвшигчдийг (хурлаар тогтоосон тооны) ХУЗ-ийн гишүүдээр батална. Сүүлчийн гишүүнд саналын тоо тэнцүү тохиолдол гарвал тухайн дэвшигчдийн хувьд дахин санал хураалт явуулна.

Б. ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- 4.16. Холбооны бүх гишүүдийн хурлаас 3 жилийн хугацаатай сонгогдсон Холбооны удирдах зөвлөл (цаашид ХУЗ гэх) холбоог удирдана.
- 4.16.1. Ээлжит тайлан сонгуулийн хурлаар шинээр сонгогдсон Удирдах зөвлөлийн гишүүдээс хамгийн ахмад нь удирдах зөвлөлийн анхны хурлыг зарлан хуралдуулж хурлыг даргална.
- 4.16.2. Шинээр сонгогдсон удирдах зөвлөлийн анхны хурлаас 7-оос доошгүй хоногийн өмнө Холбооны тэргүүнд нэр дэвшүүлэх ажлыг ил тод зарлаж хөтөлбөрийг нь авч хурлын бэлтгэлийг хангана.
- 4.17. ХУЗ-ийн дарга бөгөөд Тэргүүнийг сонгоно. Холбооны тэргүүнийг сонгохдоо дараах зарчмыг баримтална. Үүнд:
- 4.17.1. ХУЗ-ийн гишүүд нь бүрэлдэхүүнийхээ дотроос нэр дэвшүүлнэ;
- 4.17.2. ХУЗ-ийн гишүүдээс 3 хүртэл хүнийг нэр дэвшүүлнэ.
- 4.18. Холбооны тэргүүнийг дараах тохиолдолд үүрэгт ажлаас хугацаанаас нь өмнө чөлөөлөх асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:
- 4.18.1. Тэргүүн өөрөө чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;
- 4.18.2. ХУЗ-ын гишүүн болон Холбооны 10-аас доошгүй гишүүдээс Тэргүүнийг үүрэгт ажлаа хангалтгүй хийж байна гэсэн санал албан ёсоор ирүүлсэн;
- 4.18.3. энэхүү дүрмийн 2.3, 2.4-д заасан Холбооны үйл ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөөний 40-өөс дээш хувийн ажлыг зохион байгуулж хэрэгжүүлээгүй байна гэж Хяналтын зөвлөлөөс дүгнэлт гаргасан.

- 4.19. Холбооны Тэргүүнийг томилох, чөлөөлөх асуудлыг ХУЗ-ын гишүүдийн 100 хувийн ирцтэйгээр хуралдаж, гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 4.20. Нууц санал хураалт явуулан саналын тооллогыг гишүүдийн дунд илээр шууд тоолно.
- 4.21. ХУЗ-ийн гишүүнийг нөхөн сонгохдоо сонгуульт хурлын санал хураалтаар ХУЗ-д сонгогдсон гишүүдийн дараах байрт эрэмбэлэгдсэн нэр дэвшигчийг сонгоно.
- 4.22. ХУ-ийг улиралд хоёроос доошгүй удаа хуралдуулна.
- 4.23. ХУЗ нь дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:
 - 4.23.1. Удирдлага, бүтэц, зохион байгуулалтын үндсэн асуудал, үйл ажиллагааны хэтийн төлөвийг тодорхойлох;
 - 4.23.2. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;
 - 4.23.3. Эмблемийг батлах;
 - 4.23.4. Санхүүгийн бодлого, тайланг хэлэлцэж батлах;
 - 4.23.5. Тэргүүнийг сонгох, чөлөөлөх;
 - 4.23.6. Үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам, заавар, аргачлал боловсруулж мөрдүүлэх;
 - 4.23.7. Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлах.
 - 4.23.8. Цаг үеийн асуудлаар, ХУЗ-ийн дарга, гишүүн, тэргүүн, гүйцэтгэх захирлаас оруулж ирж шийдвэрлэх асуудлаар
 - 4.23.9. ХУЗ-ийн дарга, тэргүүн, гүйцэтгэх захирал, ХЗ-ийн тайланг хэлэлцэж үнэлэлт өгч дүгнэлт гаргах,
- 4.24. ХУЗ-ийн хуралд зөвлөлийн гишүүдийн олонх оролцсон тохиолдолд хурлыг хүчин төгөлдөр гэж үзнэ.
- 4.25. ХУЗ-ийн гишүүн нь Холбооны бүтцийн 2 доошгүй тооны Зөвлөлүүдэд хуваагдан орж ажиллан, Холбооны тухайн жилийн төлөвлөгөөнд хариуцан ажиллахаар заасан ажлуудын гүйцэтгэлийг хангаж ажиллах үүрэгтэй.
- 4.26. ХУЗ нь хувь хүмүүсийн асуудлыг нууцаар, бусад асуудлыг илээр санал хураах зарчмаар тэгш эрхтэй шийдвэрлэнэ.
- 4.27. ХУЗ-ийн гишүүн нь Холбооны УЗ-ийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх хөтөлбөр болон тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Тэргүүний удирдлага дор хамтран ажиллах үүрэгтэй.
- 4.28. ХУЗ-ийн гишүүн нь хүндэтгэх шалтгаангүйгээр УЗ-ын хуралд дараалан 3 удаа биечлэн оролцоогүй, Холбооноос зохион байгуулж байгаа ажлуудад оролцохгүй байгаа талаар Холбооны тэргүүнээс тодорхойлсоныг ХУЗ-ийн хурлаар хэлэлцэж УЗ-ын гишүүний үүргээс чөлөөлөх.
- 4.29. ХУЗ-ийн гишүүн нь хуралд оролцож чадахгүй хүндэтгэх шалтгаантай бол заавал урьдчилан мэдэгдэнэ.
- 4.30. ХУЗ-ийн гишүүн нь цалингүй ажиллах бөгөөд ХУЗ-ийн даргын Тэргүүний саналаар ажлын хэсэгт ажилласан тохиолдолд урамшуулал авч болно.
- 4.31. ХУЗ-ийн гишүүний эрх, үүргийг журмаар зохицуулна.
- 4.32. Онцгой тохиолдолд ХУЗ-ийн хурлыг мэргэжлийн хүмүүсийн оролцоотой өргөтгөсөн хэлбэрээр хийж болно. Урилгаар оролцсон хуулийн этгээд, хувь хүмүүс зөвлөх эрхтэй оролцоно.
- 4.33. ХУЗ нь хуралд хэлэлцсэн асуудлаар олонхын саналаар шийдвэр гаргах ба шийдвэрийг ХУЗ-ийн дарга Тэргүүн тушаал гарган баталгаажуулна.
- 4.34. ХУЗ нь бүх гишүүдийн хуралд ажлаа тайлагнана.

- 4.35. ХУЗ нь Гүйцэтгэх захирал ажил үүргээ хангалтгүй гүйцэтгэж байна гэж үзвэл Тэргүүнд хандаж хариуцлага тооцуулах санал гаргах эрхтэй.
- 4.36. ХУЗ-ийн бүрэн эрхийн 3 жилийн хугацаа дуусахаас өмнө 1 сарын дотор тэргүүн ээлжит сонгуульт хурлыг зарлан Бүх гишүүдийн хурлыг хуралдуулаагүй тохиолдолд удирдах зөвлөлийн аль нэг гишүүн хурал зарлан хуралдуулах эрхтэй.

В. ХОЛБООНЫ ТЭРГҮҮН БӨГӨӨД УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

- 4.37. Холбооны Тэргүүн нь УЗ-ийн дарга бөгөөд бүрэн эрхийн хугацаа нь 3 жил байна.
- 4.38. Удирдах зөвлөлийн дарга нь дараах үүрэгтэй байна. Үүнд:
- 4.38.1. ХУЗ-ийн хуралдааныг улиралд 2-оос доошгүй зарлан хуралдуулах, удирдах;
 - 4.38.2. ХУЗ-ийн дарга нь УЗ-ийн хурлыг даргалж, олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх;
 - 4.38.3. ХУЗ-ийн өмнө ажлаа тайлагнах, төлөвлөгөөнд тусгасан болон төлөвлөгөөнд тусгаагүй ажлыг дүгнүүлэх
 - 4.38.4. ХУЗ-ийн хурлын тэмдэглэл, ХУЗ-д ирсэн явсан бичиг баримтыг журмын дагуу хадгалах
- 4.39. ХУЗ-ийн бүрэлдэхүүнээс сонгогдсон Холбооны тэргүүн нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:
- 4.39.1. Холбооны үйл ажиллагааны өнөөгийн болон хэтийн төлөв, чиг хандлагыг тодорхойлж зөвлөлөөрөө хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах;
 - 4.39.2. Холбоог гадаад, дотоодод төлөөлөн гадаад, дотоодын хуулийн этгээд, хувь хүмүүстэй харилцах, гэрээ хэлцэл байгуулах, биелэлтийг дүгнэх.
 - 4.39.3. Улирал бүр Холбооны тухайн жилд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний биелэлт гаргаж, ХУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх;
 - 4.39.4. Холбооны гишүүнчлэлийг өргөжүүлэх талаар санал гаргаж, бүрэн эрхийнхээ хугацаанд заавал өргөжүүлсэн байх;
 - 4.39.5. Холбооны УЗ-ийн гишүүн, гишүүдээс бүрдсэн багаар төрөл бүрийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлж Холбоог санхүүгийн хувьд бэхжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах;
 - 4.39.6. Холбооны УЗ-ийн хурлаас гаргасан шийдвэрийг баталгаажуулж тушаал гаргах;
 - 4.39.7. Гүйцэтгэх захирлыг томилж, ХУЗ-д танилцуулан Хөдөлмөрийн гэрээ байгуулах, чөлөөлөх;
 - 4.39.8. Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд хяналт тавих, түүний тайланг хянах, ажилд нь үнэлэлт дүгнэлт өгөх;
 - 4.39.9. Гүйцэтгэх захирлын Холбооны мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах эрх хэмжээг тогтоох ба зардлыг баталж, гүйцэтгэлд нь хяналт тавих;
 - 4.39.10. Гүйцэтгэх захирлыг өөрийнх нь хүсэлтээр эсвэл ХУЗ-ийн гишүүн болон Холбооны гишүүдээс үүрэгт ажлаа хангалтгүй хийж байна үзвэл үүрэгт ажлаас нь Тэргүүн чөлөөлөх;
 - 4.39.11. Энэхүү дүрмийн 4.17-д заасан УЗ-ын гишүүнийг эргүүлэн татах нөхцөл бүрдсэн тохиолдолд ХУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах

санал гаргах;

4.39.12. Холбооны үйл ажиллагаатай холбогдсон тодорхой асуудлаар бусад этгээдтэй холбоо тогтоох ба бусдад шилжүүлэх;

4.39.13. Холбооны хяналтын зөвлөлийг энэхүү дүрэмд заасан эрх үүргээ хэрэгжүүлэн ажиллахыг шаардах

Г. ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

4.40. Гүйцэтгэх захирал нь Холбооны гишүүн байх ба ХУЗ-ын гишүүн байж болно.

4.41. Ажлын албаны бүрэлдэхүүнийг ХУЗ-ийн хурлаас шийдвэрлэх ба Ажлын албыг Гүйцэтгэх захирал удирдана.

4.42. Тэргүүний өгсөн үүрэг, чиглэлийн дагуу бүх гишүүдийн хурал, ХУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангуулна.

4.43. Гүйцэтгэх захирал жил бүр Холбооны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, Холбооны салбар зөвлөлийн гишүүдтэй хамтран боловсруулж түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн төслийг бэлтгэж Холбооны тэргүүнтэй зөвшилцсөний үндсэн дээр ХУЗ-ийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

4.44. Гүйцэтгэх захирал нь дор дурдсан эрх, үүрэгтэй. Үүнд:

4.44.1. ХУЗ-ийн шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, Холбооны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

4.44.2. Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, Тэргүүний зөвшөөрлөөр гадаад, дотоодод холбоог төлөөлөх;

4.44.3. Мөнгөн хөрөнгийг ХУЗ-өөс тогтоосон эрх хэмжээнд, Тэргүүний зөвшөөрлөөр захиран зарцуулах;

4.44.4. Холбооны Тэргүүнд ажлаа тогтмол, үнэн зөв тайлагнах;

4.44.5. Холбооны дүрэмд заасан үндсэн чиглэл, зорилгыг хангах салбар, нэгжийг байгуулан ажиллуулах;

4.44.6. Үйл ажиллагаатай холбоотой гарах зардал бүрийг нарийвчлан тооцож Холбооны Тэргүүнээр батлуулж гүйцэтгэлд нь хяналт хийх;

4.44.7. Холбооны санхүүгийн тайлан, бүртгэл, мэдээний үнэн зөвийг хариуцах;

4.44.8. Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож ажилласан гишүүн аж ахуйн нэгж, хувь хүмүүсийг шагнаж урамшуулахаар тодорхойлолт гаргах;

4.44.9. Гүйцэтгэх захирал нь Тэргүүнд захирагдан ажиллах ба улирал бүр үйл ажиллагааны тайланг Тэргүүн, ХУЗ-д тайлагнах;

4.44.10. Өөрийн бүрэн эрхийн хугацаа дууссан нөхцөлд шинээр гүйцэтгэх захирал томилох хүртэл албан үүргээ хэвээр гүйцэтгэх.

4.45. Санхүү татварын тайлан болон тухайн жилийн үйл ажиллагааны тайланг дараа оны 2-р сарын 15-ны дотор төрийн эрх бүхий байгууллагад холбогдох баримт бичгийн хамт хүргүүлнэ. ХУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд санхүүгийн тайлан балансад аудит хийлгэнэ.

4.46. Гүйцэтгэх захирал нь Холбооны нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх асуудлыг тэргүүнээр шийдвэрлүүлнэ. Нарийн бичгийн дарга нь орон тоогоор ажиллана.

Д. ХОЛБООНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

- 4.47. Холбооны үйл ажиллагаанд хяналт тавих хараат бус хөндлөнгийн үүрэг бүхий хяналтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр бүх гишүүдийн хурлаас 3 жилийн хугацаагаар сонгох ба бүх гишүүдийн хуралд ажлаа тайлагнана.
- 4.48. Холбооны хяналтын зөвлөл /цаашид ХЗ гэх/-ийн гишүүд нь бүрэлдэхүүнийхээ дотроос зөвлөлийн даргыг 3 жилийн хугацаагаар сонгоно.
- 4.49. ХЗ нь жилд хоёроос доошгүй удаа хуралдана. Хурлаар хэлэлцсэн асуудлын талаар олонхын саналыг үндэслэн шийдвэр гаргана.
- 4.50. ХЗ нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
- 4.50.1. Холбооны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг жилд нэг удаа шалгаж, дүгнэлт гарган ХУЗ-д танилцуулж байх;
 - 4.50.2. шалгалттай холбогдсон баримт, тайлбар, нотолгоог холбогдох хүмүүсээс шаардан гаргуулж авах;
 - 4.50.3. Холбооны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар ХУЗ-д санал оруулах;
 - 4.50.4. ХУЗ-ийн хуралд саналын эрхтэйгээр орох;
 - 4.50.5. Хийж гүйцэтгэсэн ажлаа жилийн эцсийн тайлант хуралд заавал тайлагнах;
 - 4.50.6. Үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлж, аливаа нөлөөнд автахгүй байх;

Е. ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ЗАЛУУ ИНЖЕНЕРҮҮДИЙН КЛУБ

- 4.51. Үйл ажиллагааг дэмжих залуу инженерүүдийн клуб /цаашид ЗИК гэх/ нь МГФЗЗМХолбооны үйл ажиллагааг дэмжин ажиллах залуучуудын эвлэлдэн нэгдсэн Холбооны дэргэдэх бүтцийн байгууллага байна.
- 4.52. ЗИК нь Холбооны дүрэмд захирагдахуйц, ХУЗ-өөр хянуулж, Холбооны тэргүүнээр батлуулсан дүрмийг баримтлан бие даасан бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулна.
- 4.53. Үйл ажиллагааны үндсэн чиглэл нь залуучуудын эв нэгдлийг ханган Холбооны үйл ажиллагаанд оролцох идэвхийг нэмэгдүүлэх, урлаг, спорт, танин мэдэхүйн энтертайнмент үйл ажиллагааг явуулах, гадаад дотоод ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг залуучуудын байгууллагуудтай холбоо харилцаагаа нэмэгдүүлэх, мэргэжлийн чиглэлийн хамтарсан судалгаа шинжилгээний ажил явуулахад чиглэнэ.
- 4.54. ЗИК нь дараах эрх, үүргийг хүлээнэ. Үүнд:
- 4.54.1. Үйл ажиллагааны хөтөлбөрийг жилээр боловсруулан ХУЗ-д танилцуулж Холбооны Тэргүүнээр батлуулан түүний дагуу үйл ажиллагаагаа явуулах;
 - 4.54.2. Үйл ажиллагаа явуулахад төлөвлөсөн ажлын төсвийн хүрээнд Холбооноос санхүүжилтийн дэмжлэг авах.

ТАВ. ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТ

- 5.1. Холбооны үйл ажиллагааны санхүүжилт нь дор дурдсан үндсэн эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- 5.1.1. Гишүүдийн татвар, хандив тусламж, өв хөрөнгө
- 5.1.2. Дотоод, гадаадын түнш байгууллагын хандив тусламж
- 5.1.3. Дүрмийн зорилготой нийцэх сургалт, аж ахуйн үйл ажиллагааны орлого болон төслийн хэрэгжилт
- 5.1.4. Төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлж түүнээс олсон орлого, төрийн байгууллагаас чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын санхүүжилт
- 5.2. Холбооны санхүүгийн үйл ажиллагаа нь Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд явагдах бөгөөд тайлагнах, мэдээлэх асуудлыг холбогдох хууль, эрхзүйн актын дагуу хэрэгжүүлнэ.
- 5.3. Холбооны санхүүжилт, зарлагыг зохицуулах журмын хүрээнд санхүүгийн үйл ажиллагааг явуулна.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

- 6.1. Холбооны болон ХУЗ-ийн гишүүний хууль бус үйл ажиллагааны улмаас байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд учирсан хохирол, түүнээс үүсэх хариуцлагыг Холбоо хүлээхгүй.
- 6.2. Холбооны орлогоос ашиг хуваарилах, байгууллага аж ахуйн нэгжийн төлбөрийг төлөх, ашиг олох, нам эвсэл, нэр дэвшигчдэд эд хөрөнгө хандив өгөхийг хориглох бөгөөд түүнийг зөрчсөн тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

ДОЛОО. ХОЛБООГ ТАТАН БУУЛГАХ

- 7.1. Холбоо нь дүрэмд заасан зорилгоо бүрэн хэрэгжүүлж дууссан, цаашид төрийн бус байгууллагын хэлбэрээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагагүй гэж гишүүдийн хурлаас олонхын саналаар шийдвэрлэвэл татан буулгаж болно.
- 7.2. Татан буугдсан шийдвэрээ 21 хоногийн дотор нийтэд мэдээлж, эрх бүхий байгууллагад албан бичгээр хүргүүлж, улсын бүртгэлээс хасуулна.
- 7.3. Холбооны хөрөнгийг ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагад шилжүүлэх бөгөөд тийм төрийн бус байгууллага байхгүй нөхцөлд зорилгод нь нийцсэн үйл ажиллагаанд зарцуулна.

Хаяг: СБД-ийн 7-р хороо, 11-р хороолол Их Тойруу 82-т байрлах “Мөнхбүл Түшиг” ХХК барилгын 3 давхар 307 тоот

-ooOoo-